



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

**ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН “ХӨДӨӨ АЖ АХУЙ ДАХЬ
ХӨДӨЛМӨРИЙН ХЯНАЛТЫН ТУХАЙ” 129 ДҮГЭЭР КОНВЕНЦЫГ СОЁРХОН
БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ
ЗАРДЛЫН ТООЦОО**

Улаанбаатар хот

2025 он

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЗГ – Засгийн газар

ЗГХЭГ – Засгийн газрын хэрэг эрхлэх газар

МҮЭХ – Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо

МАОЭНХ – Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо

МҮХАҮТ- Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим

ХАБЭА – Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

ААНБ – Аж ахуйн нэгж, байгууллага

ҮСХ – Үндэсний статистикийн хороо

ҮОМШӨ – Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин

ХАБЭМ - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд

ҮОХХ – Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого

“ХӨДӨӨ АЖ АХУЙ ДАХЬ ХӨДӨЛМӨРИЙН ХЯНАЛТЫН ТУХАЙ” 129 ДҮГЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу “Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 1969 оны 129 дүгээр конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/ батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан тооцож үзэв.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах зардлын тооцоог хийх шаардлага нь төслийн үр нөлөөг урьдчилан тандан судлах, хуулийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг тооцоолох болон холбогдох зардлын ачааллыг бууруулах боломж буй эсэхийг үнэлэх, санал боловсруулахад чиглэсэн.

Уг аргачлалын 1.5 дахь хэсэгт зааснаар зардлын тооцоог хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагад үүсэх гэсэн төрлөөр тооцохоор тусгаж, холбогдон гарах зардлыг бууруулах боломж байгаа эсэхийг судлан, санал боловсруулсан.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход доор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан болно. Үүнд:

- иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАРДЛЫГ ТООЦОХ

Хуулийн этгээдийн зардлыг тооцохдоо аргачлалын 2.1-д заасны дагуу

- 1) Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 2) Зардлыг тооцох;
- 3) Тоон үзүүлэлтийг тооцох;

- 4) Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 5) Хялбарчлах боломжийг шалгах;
- 6) Нэмэлт зардлыг тооцох үе шатаар хуульд заасан үүргээ гүйцэтгэхтэй холбогдон гарах мөнгөн зардлыг тооцсон.

2.1. Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох

Аргачлалын 2.3-т “Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоохдоо хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг (цаашид “үүрэг” гэх) нэг бүрийг тогтооно. Гүйцэтгэх үүрэг гэж тухайн хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд хуульд заасны дагуу тоо баримт, тайлан, холбогдох бусад мэдээлэл (цаашид “мэдээлэл” гэх)-ийг бэлтгэн төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд гаргаж өгөх, эсхүл хүргүүлэхийг хэлнэ.” гэжээ. Үүнд бүх төрлийн өргөдөл, хүсэлт, маягт бөглөх, статистик тоо мэдээ өгөх, бүртгүүлэх, нөхөн олговор, төрөөс тусламж, дэмжлэг, зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл гаргах, зөвшөөрөл хүсэх гэх мэт үүргүүд хамаарна. Хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээдэд эрх зүйн зохицуулалтаар тусгасан үүрэг нэг бүрийг энэхүү үе шатанд тогтоох зорилттой тул хуулийн этгээдээс төрийн байгууллага, гуравдагч этгээдтэй харилцах харилцаанд үүсэх үүргээс гадна хуулийн этгээдийн захиргааны шинжтэй дотоод үүргийг мөн авч үзэв.

“Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай” 129 дүгээр конвенцод хуулийн этгээдийн хүлээх үүргийг дараах байдлаар зааж өгсөн байдаг.

Хүснэгт 1. Хуулийн этгээдийн хүлээх үүрэг

Холбогдох зохицуулалт	Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Гүйцэтгэх үүрэг
(I) Хуулийн заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа асуудлаар ажил олгогч, эсхүл ажилтнаас ганцаарчлан, эсхүл гэрчийн дэргэд асууж лавлах	Шалгуулагч этгээд, хяналтын байгууллага, холбогдох бусад этгээд	Тайлбар өгөх: - биечлэн тайлбар өгөхөд асуултад хариулт өгөх; - бичгээр тайлбар өгөх

(II) Ажлын нөхцөлтэй холбоотой дотоодын хууль тогтоомжид заасны дагуу хуулийг хэрэгжүүлж буй эсэхийг харахын тулд холбогдох данс, бүртгэл, тооцоо болон бусад баримт бичгийг шаардах, эдгээр баримт бичгийг хуулбарлах, эсхүл эдгээрээс сонгож авах	Шалгуулагч этгээд, хяналтын байгууллага, холбогдох бусад этгээд	Улсын байцаагчид цахим болон цаасан суурьтай баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх
(III) Шинжлэх зорилгоор ашиглаж хэрэглэж буй материал, эд зүйлсээс шинжилгээ хийх зорилгоор авч байгаа гэдгээ ажил олгогч, түүний төлөөлөлд мэдэгдсэний үндсэн дээр дээж авах	Шалгуулагч этгээд, хяналтын байгууллага, холбогдох бусад этгээд	Улсын байцаагчид шаардлагатай дээжийг авах боломжийг бүрдүүлэх
Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдлын талаар хөдөлмөрийн хяналтын албанд дотоодын хууль тогтоомжид заасны дагуу мэдээлнэ.	Хуулийн этгээд	Улсын байцаагчид цахим болон цаасан суурьтай баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх

2.2. Хуулийн этгээдийн захиргааны зардлыг тооцох

Дээрх конвенцод зааснаар хуулийн этгээдэд шалгалтын талаар хүлээлгэсэн 4 үүрэг нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд тус тус байгаа үүргүүд тул захиргааны нэмэлт зардлыг тооцох шаардлагагүй байна.

2.3. Тоон үзүүлэлтийг тооцох

Тоон үзүүлэлтийг тохиолдлын тоог давтамжийн тоогоор үржүүлэн тооцдог. Тодруулбал, энэ үе шатанд тухайн үүргийг гүйцэтгэх хуулийн этгээд болон нэг жилд гүйцэтгэх давтамжийн тоогоор тооцно. Хуулийн төслөөр хуулийн этгээдэд шинээр үүрэг үүсээгүй тул тоон үзүүлэлтийг тооцох шаардлагагүй байна.

2.4. Нийт зардлын дүнг тооцох

Хуулийн этгээдэд шинээр үүрэг үүсээгүй тул нэмэгдэх зардал байхгүй. Хуулийн этгээдээс гардаг захиргааны зардал мөн хэмжээгээр гарна.

2.5.Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах

Энэ үе шатанд үүрэг нэг бүрийн зардлыг бууруулах, хуулийн этгээдэд үүсгэх дарамт, ачааллыг багасгах боломж байгаа эсэхийг шалгана. Хуулийн этгээдэд шинээр үүрэг үүсгээгүй тул зардлыг бууруулах, хуулийн этгээдэд үүсгэх дарамт, ачааллыг багасгах боломж байгаа эсэхийг шалгах шаардлага байхгүй болно.

2.6.Нэмэлт зардлыг тооцох

Энэ үе шатанд үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарч болох нэмэлт зардлыг тооцно. Нэмэлт зардлыг тооцоход ашиглах арга, томьёо байхгүй тул аргачлалд заасан зардал тооцох аргыг хэрэглэдэг. Хуулийн төсөлд шинээр хүлээлгэсэн үүрэггүй тул нэмэлт зардлыг тооцох шаардлагагүй байна.

ХОЁР.ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ, АЧААЛЛЫН ТООЦОО

Иргэнд үүсэх зардал, ачааллыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан аргачлалын дагуу дараах таван үе шатаар тооцно:

- 1.Үүргийг тогтоох;
- 2.Хугацаа, зардал тооцох;
- 3.Тоон үзүүлэлтийг тооцох;
- 4.Нийт дүнг тооцож гаргах;
- 5.Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах.

Иргэний хувьд хууль тогтоомжид тусгагдсан үүргийг гүйцэтгэхэд холбогдон гарах мөнгөн зардлаас гадна зарцуулах хугацаа буюу ачааллыг тооцох онцлогтой юм.

3.1.Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох

Хуулиар хүлээлгэсэн үүргийг болон үүргийн агуулгыг тодорхойлох гэсэн хоёр алхмаар иргэний гүйцэтгэх үүргийг тогтооно. Иргэний гүйцэтгэх үүргийг нэг бүрчлэн, үүргийн агуулга нэг бүрийг тодорхойлно. Энэхүү гүйцэтгэх үүрэгт тухайн хуулиар үүрэг хүлээж буй иргэнээс хуульд заасан мэдээллийг төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд бэлтгэж өгөх, бэлэн байлгах, эсвэл мэдээлэл хүргүүлэхийг ойлгоно.

Хүснэгт 2. Иргэний хүлээх үүрэг

Холбогдох зохицуулалт	Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Гүйцэтгэх үүрэг
(I) Хуулийн заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа асуудлаар ажил олгогч, эсхүл ажилтнаас ганцаарчлан, эсхүл гэрчийн дэргэд асууж лавлах	Шалгуулагч этгээд, хяналтын байгууллага, холбогдох бусад этгээд	Тайлбар өгөх: - биечлэн тайлбар өгөхөд асуултад хариулт өгөх; - бичгээр тайлбар өгөх
(II) Ажлын нөхцөлтэй холбоотой дотоодын хууль тогтоомжид заасны дагуу хуулийг хэрэгжүүлж буй эсэхийг харахын тулд холбогдох данс, бүртгэл, тооцоо болон бусад баримт бичгийг шаардах, эдгээр баримт бичгийг хуулбарлах, эсхүл эдгээрээс сонгож авах	Шалгуулагч этгээд, хяналтын байгууллага, холбогдох бусад этгээд	Улсын байцаагчид цахим болон цаасан суурьтай баримт бичиг, мэдээллийг гаргаж өгөх
(III) Шинжлэх зорилгоор ашиглаж хэрэглэж буй материал, эд зүйлсээс шинжилгээ хийх зорилгоор авч байгаа гэдгээ ажил олгогч, түүний төлөөлөлд мэдэгдсэний үндсэн дээр дээж авах	Шалгуулагч этгээд, хяналтын байгууллага, холбогдох бусад этгээд	Улсын байцаагчид шаардлагатай дээжийг авах боломжийг бүрдүүлэх

3.2. Иргэнд үүсэх зардал, ачааллыг тооцох

Хуулийн төслөөр иргэнд шалгалтын талаар хүлээлгэсэн 3 үүрэг нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд тус тус байгаа үүргүүд тул захиргааны нэмэлт зардлыг тооцох шаардлагагүй байна.

3.3. Тоон үзүүлэлтийг тооцох

Тоон үзүүлэлтийг тохиолдлын тоог давтамжийн тоогоор үржүүлэн тооцдог. Тодруулбал, энэ үе шатанд тухайн үүргийг гүйцэтгэх иргэн болон нэг жилд гүйцэтгэх давтамжийн тоогоор тооцно. Хуулийн төслөөр иргэнд шинээр үүрэг үүсээгүй тул тоон үзүүлэлтийг тооцох шаардлагагүй байна.

3.4. Нийт зардал, ачааллын дүнг тооцох

Иргэнд шинээр үүрэг үүсээгүй тул нэмэгдэх зардал байхгүй.

3.5.Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах

Энэ үе шатанд үүрэг нэг бүрийн зардлыг бууруулах, иргэнд үүсгэх дарамт, ачааллыг багасгах боломж байгаа эсэхийг шалгана. Иргэнд шинээр үүрэг үүсгээгүй тул зардлыг бууруулах, иргэнд үүсгэх дарамт, ачааллыг багасгах боломж байгаа эсэхийг шалгах шаардлага байхгүй болно.

ДӨРӨВ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Төрийн байгууллагын зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан аргачлалын дагуу дараах таван үе шатаар тооцно:

- 1.Үүргийг тогтоох;
- 2.Хүний нөөцийг тодорхойлох;
- 3.Гарах зардлыг тооцох;
- 4.Нийт зардлын дүнг тооцох;
- 5.Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

4.1.Төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг тогтоох

Төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг зарцуулах хугацаа болон тохиолдлын тоог тодорхойлох гэсэн хоёр дарааллаар тогтооно. Хуулийн төслийн зохицуулалтаар үүрэг хүлээсэн байгууллага нэг бүрийг; түүний гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг нэг бүрчлэн тодорхойлно.

Хүснэгт 3. Төрийн байгууллагын хүлээх үүрэг

Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт	Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Гүйцэтгэх үүрэг
Тухайн гишүүний захиргааны тогтолцоо дахь нийтлэг туршлагатай аль болох нийцүүлэх байдлаар хөдөлмөрийн хяналтыг төрийн захиргааны төв байгууллагын удирдлага, хяналт дор зохион байгуулбал зохино.	Засгийн газар	Зохион байгуулалтыг шийдвэрлэх
Эрх бүхий байгууллага дараах үйл ажиллагааг дэмжинэ.	ЗГХЭГ, бусад яамдын Хяналтын газрууд, аймаг, дүүргийн	Уялдаа холбоотой ажиллах

Хяналтын албад, Засгийн газрын бусад алба, түүнчлэн тэдгээртэй ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн, эсхүл хувийн байгууллага хоорондын үр дүнтэй хамтын ажиллагааг;	захиргааны байгууллагууд	
Хөдөлмөрийн хяналтын албан хаагч, ажил олгогч болон ажилтан, эсхүл тэднийг төлөөлөх байгууллага хоорондын хамтын ажиллагааг;	МАОЭНХ, МХАҮҮТ, МҮЭХ	Хамтын ажиллагааг өргөжүүлэх
Тухайн ажил үйлчилгээний шаардлагад нийцсэн зохих тоног төхөөрөмжөөр хангагдсан бөгөөд холбогдох бүх хүмүүст хүртээмжтэй албан газар;	Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Шаардлагад нийцсэн зохих тоног төхөөрөмжөөр хангах
Нийтийн тээврийн тохиромжтой хэрэгсэл байхгүй тохиолдолд ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тээврийн хэрэгсэл;	Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тээврийн хэрэгслээр хангах
Эрх бүхий байгууллага нь хөдөлмөрийн хяналтын байцаагчид ажил үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах аливаа тээврийн болон урьдчилан тооцоолоогүй зардлыг нөхөж олгох талаар шаардлагатай зохицуулалтыг хийнэ.	Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Тооцоолоогүй зардлыг нөхөн гаргах
(I) Хуулийн заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа асуудлаар ажил олгогч, эсхүл ажилтнаас ганцаарчлан, эсхүл гэрчийн дэргэд асууж лавлах	Улсын байцаагч	Тайлбар авах: - биечлэн тайлбар авах, асуултад хариулт өгөх; - бичгээр тайлбар авах
(II) Ажлын нөхцөлтэй холбоотой дотоодын хууль тогтоомжид заасны дагуу хуулийг хэрэгжүүлж буй эсэхийг харахын тулд холбогдох данс, бүртгэл, тооцоо болон бусад	Улсын байцаагч	Цахим болон цаасан суурьтай баримт бичиг, мэдээллийг гаргуулан авах

баримт бичгийг шаардах, эдгээр баримт бичгийг хуулбарлах, эсхүл эдгээрээс сонгож авах		
(III) Шинжлэх зорилгоор ашиглаж хэрэглэж буй материал, эд зүйлсээс шинжилгээ хийх зорилгоор авч байгаа гэдгээ ажил олгогч, түүний төлөөлөлд мэдэгдсэний үндсэн дээр дээж авах	Улсын байцаагч	Шаардлагатай дээжийг авах
(IV) Эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой хуулийн заалтын биелэлтийг хангах шаардлагын үүднээс үйлдвэрлэлийн барилга байгууламж, эсхүл тоног төхөөрөмжид, тодорхой заасан хугацааны дотор өөрчлөлт оруулах	Улсын байцаагч	Үйл ажиллагаа түр зогсоох
(V) Эрүүл мэнд, аюулгүй байдалд болзошгүй аюул занал учруулахуйц тохиолдолд үйлдвэрлэлийн үйл ажиллагааг зогсоохыг шаардсан шуурхай арга хэмжээ авах	Улсын байцаагч, хяналтын прокурор	Үйл ажиллагааг зогсоох саналыг холбогдох байгууллагад хүргүүлэх
(VI) Хөдөлмөрийн хяналтын байцаагчийн сахиулдаг хуулийн заалтыг зөрчсөн, эсхүл дагаж мөрдөхөөс зайлсхийсэн хүмүүст урьдчилан мэдэгдэхгүйгээр эрх зүйн арга хэмжээг оногдуулж болно. Гэхдээ урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах болон тухайн зөрчилт байдлыг арилгахын тулд дээр дурдсан хүмүүст урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр арга хэмжээ авах нөхцөлийг дотоодын хууль тогтоомжийн дагуу тогтооно.	Улсын байцаагч	Хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ тооцох
(VII) Хөдөлмөрийн хяналтын байцаагч, эсхүл орон нутгийн хяналтын алба нь үйл ажиллагааныхаа үр дүнгийн талаарх тайланг гаргаж, хяналтын төв байгууллагад тогтмол хүргүүлэхийг шаардана.	Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага	Тайлан гаргаж хүргүүлэх

(VIII) Хяналтын төв байгууллага нь өөрийн харьяа албадын жилийн ажлын ерөнхий тайланг хэвлүүлж, хувийг 3 сарын дотор Олон улсын хөдөлмөрийн байгууллагад хүргүүлнэ.	Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Тайланг хэвлүүлж хүргүүлэх
---	--	----------------------------

Хуулийн төслийн зохицуулалтаар төрийн болон орон нутгийн захиргааны 8 байгууллага, 2 албан тушаалтанд үүрэг хүлээлгэжээ. Төрийн болон орон нутгийн захиргааны 8 байгууллагыг дурдвал: 1/.Засгийн газар, 2/. ЗГХЭГ болон бусад яамдын хяналт шалгалтын байгууллага; 3/. МҮЭХ; 4/. МАОЭНХ; 5/. МҮХАҮТ; 6/. Мэргэжлийн холбоод; 7/. Хөдөлмөрийн хяналтын төв байгууллага; 5/. Прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага; 6/. агентлаг; 8/.нутгийн захиргааны байгууллага. Хуулиар үүрэг хүлээлгэсэн 2 албан тушаалтныг дурдвал: 1/.улсын байцаагч; 2/.прокурор;

Дээр дурдсан 14 үүрэг нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиар тус тус хуульчилсан, нэгэнт хийгддэг үүрэг тул стандарт ажиллагааг тодорхойлох шаардлагагүй бөгөөд нэмэлт зардал шаардахгүй болно.

4.2.Ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

Хуулийн төслөөр шинээр нэмэгдсэн төрийн байгууллагын үүрэг буюу ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох ажиллагааг дараах гурван алхмаар гүйцэтгэдэг:

- зарцуулах хугацааг тодорхойлох;
- тохиолдлын тоог тодорхойлох;
- шаардагдах нийт ажлын цагийг тогтоох.

Хуулийн төсөлд хөдөлмөрийн хяналтын байгууллагад шинээр үүрэг хүлээлгээгүй тул тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох шаардлагагүй болно.

4.3.Гарах зардлыг тооцох

Төрийн захиргааны байгууллагад буюу төрөөс гарах зардлыг урьдчилан тооцох үе шатанд:

- Хүний нөөцийн зардал (төрийн албан хаагчтай холбоотой шууд болон шууд бусаар үүсэх зардал);
- Материаллаг зардал (төрийн албан хаагчийн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардал);

- Бусад зардал (тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд дагалдан гарах зардал)-ыг тооцож гаргана.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлд хяналтын ажилтны статус, ажлын нөхцөл нь Засгийн газрын өөрчлөлт, гадны зохисгүй нөлөөнөөс хараат бус байж, хөдөлмөр эрхлэх баталгаа нь хангагдсан төрийн албан хаагчаас бүрдэнэ гэсэн байх бөгөөд манай улсын хөдөлмөрийн хяналтын байцаагч нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн албаны тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд зааснаар дээрх эрх нь баталгаажиж байна.

Хөдөлмөрийн хяналтын байгууллагын хүний нөөцийн орон тоо системийн хэмжээнд өөрчлөгдөхгүй тул материаллаг болон бусад зардлын хэмжээнд өөрчлөлт орохгүй болно. Иймд материаллаг болон бусад зардлыг тооцох шаардлагагүй хэмээн үзэв.

4.4.Нийт зардлын дүнг тооцох

Гүйцэтгэх үүрэгтэй холбоотой хүний нөөцийн тодорхойлж, гарах зардлыг тооцоолж үзэхэд төрийн байгууллагаас буюу төрд үүсэх нийт зардлыг тооцох шаардлагагүй байна.

4.5.Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Энэ үе шатанд төсвийн зардлыг багасгаж болох эсэх, зохицуулалтын өөр хувилбар байгаа эсэх, ачааллыг бууруулах боломж байгаа эсэхийг нягтална. Төрийн байгууллагад шинээр үүрэг нэмэгдээгүй тул чиг үүргээ хэрэгжүүлэхэд гарах нэмэлт зардлын асуудал үүсэхгүй.

Хөдөлмөрийн хяналтын байгууллагын улсын байцаагч, албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар шинэлэг зохицуулалт хуулийн төсөлд тусгагдаагүй тул уг зардлыг тооцох шаардлагагүй байна.

ТАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн, 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ыг удирдлага болгон зардлын тооцоог гаргалаа.


Аргачлалын 1 дүгээр зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг төрийн байгууллагын зардал, хуулийн этгээдийн зардал, иргэнд үүсэх зардал гэсэн 3 төрлөөр тооцоход хуулийн төсөлд дээрх этгээдүүдэд шинээр үүрэг үүсээгүй тул нэмэгдэх зардал байхгүй буюу өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн

албаны тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хүрээнд зардал нь багтаж байна.

Иймд энэхүү хуулийн төсөл нь хуулийн этгээд, иргэнд хүндрэл, бэрхшээлгүй, төрийн байгууллагын зардалд нөлөөлөхгүй гэж дүгнэв.

Жич: Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд төрийн захиргааны хяналт шалгалтын зардал нь улсын төсвөөс санхүүжигддэг бөгөөд хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр улсын хэмжээнд хийсэн 2023 оны хяналт шалгалтын зардлын тооцоог хавсралт 1 –ээр харуулав.

Хүснэгт 3. Гүйцэтгэсэн хяналт шалгалтын тоо (2019-2023 он)



Сүүлийн 5 жилд хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр нийт 15369 объектод хяналт шалгалт хийсэн нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуйн нэгж, байгууллагын 15,8 хувийг хамаарч байна.

Хавсралт 1

**УЛСЫН ХЭМЖЭЭНД 2023 ОНД ТӨЛӨВЛӨСӨН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Аймаг, агентлаг, дүүрэг	Албан томилолт	Шатахуун	Ажлын хувцас хамгаалах хэрэгсэл	Сургалт, сурталчилгаа	Ослын дуудлагаар ажиллах /томилолт, шатахууны зардал /	
			Мөнгөн дүн			Мөнгөн дүн	Тайлбар
1	Архангай	2,560,000	7,000,000	2,878,000	2,200,000	1,840,000	19 сум, алслал нь 110 км
2	Баян-Өлгий	6,912,000	3,120,000	5,200,000	5,760,000	640,000	13 сум 1 тосгон, алслал 110 км
3	Баянхонгор	8,704,000	7,946,120	6,000,000	2,500,000	1,238,230	20 сум, алслал 100 км
4	Булган	8,192,000	2,646,000	5,460,000	3,750,000	2,000,000	16 сум, алслал 100 км
5	Говьсүмбэр	223,448	2,160,000	1,800,000	300,000	500,000	3 сум, алслал 45 км
6	Говь-Алтай	17,408,000	5,845,455	3,840,000	1,500,000	565,950	18 сум 2 тосгон, алслал 320 км
7	Дархан-уул	384,000	2,160,000	1,940,000	1,500,000	240,000	4 сум, алслал 45 км
8	Дорнод	8,640,000	2,530,000	6,000,000	-	3,000,000	14 сум, алслал 65 км
9	Дорноговь	11,520,000	34,971,300	2,520,000	3,500,000	5,850,000	14 сум, алслал 100 км

10	Дундговь	3,840,000	2,816,000	4,770,000	2,000,000	537,600	14 сум, алслал 100 км
11	Завхан	15,616,000	3,726,418	4,850,000	3,000,000	739,100	24 сум, алслал 110 км
12	Орхон	4,814,400	7,171,200	4,668,000	1,000,000	2,000,000	14 сум, алслал 100 км
13	Өвөрхангай	5,760,000	3,675,952	3,975,000	1,500,000	741,000	19 сум, алслал 100 км
14	Өмнөговь	18,932,500	1,781,500	9,500,000	3,000,000	5,000,000	15 сум, алслал 80 км
15	Сүхбаатар	4,608,000	10,172,250	2,283,300	1,560,000	1,862,344	12 сум, алслал 110 км
16	Сэлэнгэ	4,800,000	3,589,500	10,000,000	2,200,000	4,000,000	17 сум, алслал 75 км
17	Төв	6,144,000	2,725,480	2,525,000	3,250,000	1,240,000	27 сум, алслал 110 км
18	Увс	2,500,000	719,800	875,000	800,000	600,000	8 сум, алслал 110 км
19	Ховд	7,512,000	4,054,300	1,600,000	535,000	1,200,000	8 сум, алслал 110 км
20	Хөвсгөл	4,800,000	10,800,000	7,500,000	1,000,000	4,000,000	24 сум, алслал 75 км
21	Хэнтий	21,632,000	3,036,000	4,515,000	2,250,000	2,973,600	18 сум, 5 тосгон, алслал 85 км
22	ХХҮЕГ		7,500,000	4,250,000	50,000,000	3,750,000	Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэр

23	Нийслэл		956,000	4,000,000	500,000	478,000.0	9 дүүрэг
25	Баянгол дүүрэг		6,309,600	3,200,000	3,000,000	1,000,000.0	2 улсын байцаагч
26	Баянзүрх дүүрэг		2,094,400	9,000,000	1,500,000	1,300,000	2 улсын байцаагч
27	Сүхбаатар дүүрэг		8,365,000	4,750,000	20,000,000	2,000,000	2 улсын байцаагч
28	Сонгинохайрхан дүүрэг		9,464,400	4,000,000	25,000,000	1,650,000	2 улсын байцаагч
29	Хан-Уул дүүрэг		4,433,450	4,995,000	6,400,000	1,300,000	2 улсын байцаагч
30	Чингэлтэй дүүрэг		3,633,000	3,920,000	20,000,000	1,406,400	2 улсын байцаагч
31	Налайх дүүрэг		1,601,300	1,000,000	2,000,000	597,500	2 улсын байцаагч
32	Багануур дүүрэг	384,000	2,772,084	962,000	2,000,000	488,000	2 улсын байцаагч
33	ДҮН	165,502,348	169,776,509	132,776,300	173,505,000	54,737,724	-

Улсын хэмжээнд 2023 онд хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуйн чиглэлээр 2413 объектод 82 улсын байцаагч төлөвлөгөөт, урьдчилан сэргийлэх болон төлөвлөгөөт бус арга хэмжээний зардалд ойролцоогоор нийт 700 сая төгрөг төсөвлөсөн байна. Үүнээс учирч болзошгүй үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын ослын дуудлагын үйл ажиллагааны зардалд нийт 107,555 км замаар тооцож, 54.7 сая төгрөг төсөвлөсөн байна. Зардлын бүтцийн хувьд сургалт, сурталчилгаанд 173.5 сая, шатахуунд 169.8 сая төгрөг буюу хамгийн өндөр зардал гарахаар тооцоолсон байна.

Улсын байцаагчдын орон тооны мэдээлэл

Хяналтын чиглэл	Батлагдсан орон тоо	Үүнээс		
		Одоо ажиллаж байгаа	Хүүхэд асрах чөлөөтэй	Сул орон тоо
Хөдөлмөр	78	66	3	9

Хөдөлмөрийн эрүүл ахуй	34	16	2	16
Нийт	112	82	5	25

Хяналт шалгалт хийх 82 улсын байцаагчийн ажлын хувцас, хамгаалах хэрэгсэлд 132.8 сая төгрөг, хяналт шалгалт хийх албан томилолтын зардалд 165.5 сая төгрөг, бусад зардалд 54.7 сая төгрөг зарцуулахаар тооцсон байна.

Дээрх зардалд дүгнэлт хийхэд аймаг, дүүргийн газарзүйн алслал, нутаг дэвсгэрийн хэмжээ, аж ахуйн нэгж байгууллагын тоо, шалгалтын цар хүрээтэй шууд уялдаж (жишээ нь: Говь-Алтай, Хэнтий, Баянхонгор, Өмнөговь) томилолт, шатахууны зардал өндөр байна. Нийслэлийн хэмжээнд томилолтын зардал бага боловч сургалт, сурталчилгаа болон ажлын хувцасны зардал өндөр байна.

Хөдөлмөр, хөдөлмөрийн хяналтын чиглэлээр Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай зэрэг хөдөлмөрийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн төлөвлөгөөт, урьдчилан сэргийлэх, төлөвлөгөөт бус хяналт шалгалтын явцад 2023 онд нийт 3946 объектод хяналт шалгалт хийж, 33046 зөрчил илрүүлж, 426,450,000 /дөрвөн зуун хорин зургаан сая дөрвөн зуун тавин мянга/ төгрөгийн торгууль, улсын байцаагчийн 1870 хугацаатай албан шаардлага, 11,640,900,3 /арван нэгэн тэр бум зургаан зуун дөчин сая есөн зуун мянга гурван зуу/ сая төгрөгийн нөхөн төлбөр тогтоож ажилласан ба нийт төлөвлөсөн хяналт шалгалтын зардлын 70 гаруй хувь буюу 490 гаруй сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлж зарцуулсан байна.

_____оОо_____

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Нэг.Хууль тогтоомж

- 1.1.Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- 1.2.Төрийн албаны тухай хууль;
- 1.3.Хөдөлмөрийн тухай хууль;
- 1.4.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль;
- 1.5.Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”.

Хоёр.Нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт

- 2.1.Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”;
- 2.2.Засгийн газрын 2020.12.09-ний өдрийн 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”.

Гурав.Судалгааны тайлан

- 3.1.Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ” судалгааны тайлан, Улаанбаатар хот, 2021 он.

Дөрөв.Цахим хуудас

- 4.1.Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, www.1212.mn.